



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/252

Улаанбаатар хот

Дотоод хяналт шалгалтын журамд
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8. дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн нэмсүгэй.


1.1."9.2 Иргэн, хуулийн этгээд, байгууллагын албан хаагчаас хууль, дүрэм, журам, заавар зөрчсөн, авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой зөрчлийн талаар амаар болон бичгээр эсхүл цахимаар мэдээлэл өгсөн тохиолдолд тухайн мэдээлэл өгч, шүгэл үлээсэн аливаа этгээдийн нууцыг хамгаална."

1.2."9.3 Албан хаагч өөрийн болон бусдын сахилга, ёс зүйн зөрчлийг сайн дураараа илчилж, мэдэгдсэн, мөн болгоомжгүйгээр зөрчил гаргасан тохиолдолд түүний хариуцлагыг зөрчлийн шинж чанар, нөхцөл байдлыг харгалзан хөнгөрүүлж тооцож болно.

1.3."9.4 Энэ журмыг зөрчсөн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

2.Журамд орсон өөрчлөлтийг албан хаагчдад танилцуулж, дагаж мөрдөхийг зохион байгуулалтын нэгжийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

17251951